



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2022/08/НА-СБА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт хот 2022 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: М.Нарантуяа</p> <p>Утас: 70518369      Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа</p> <p>Утас: 70512123      Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор:              О.Барчидгүнсэн</p> <p>Утас: 70512127      Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн хурал
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
Б.ГАНТУЛГА ТАНАА

2022.08.24 № 18  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>210,682,439.10</u></b>	<b><u>284,589,524.20</u></b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	00.00	66,114,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	00.00	66,114,000.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	00.00	66,114,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	210,682,439.10	218,475,524.20
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	58,245,167.60	64,009,760.70
35110	Тусгай зориулалттай материал	49,954,407.60	52,551,030.70
35130	Эм боох материал	8,290,760.00	11,458,730.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	85,884,483.50	88,059,538.50
35410	Бичиг хэргийн материал	13,769,732.00	4,534,520.00
35420	Аж ахуйн материал	2,228,820.00	2,145,120.00
35430	Сэлбэг хэрэгсэл	100,000.00	100,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,563,348.00	8,766,485.00
35470	Бусад хангамжийн материал	66,222,583.50	72,513,413.50
35600	Мал амьтад	66,552,788.00	66,406,225.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,844,188,364.22</u></b>	<b><u>1,796,746,558.08</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,844,188,364.22	1,796,746,558.08
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,597,022,964.26	1,549,796,158.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	982,244,741.00	982,177,601.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,601,847.78	-107,470,943.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	494,991,778.57	559,977,511.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	-204,755,137.59	-251,886,289.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	398,013,239.75	447,304,254.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-122,833,214.01	-194,233,053.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,021,434.80	64,965,034.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,549,330.22	-36,840,449.42
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	42,788,342.78	42,788,342.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,694,595.75	57,798,845.75
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,991,638.79	-14,784,696.71
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	247,165,399.96	246,950,400.00
39301	Програм хангамж	520,000.00	520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-215,000.04	-430,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	246,860,400.00	246,860,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,054,870,803.32</u></b>	<b><u>2,081,336,082.28</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,054,870,803.32</u></b>	<b><u>2,081,336,082.28</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,054,870,803.32	2,081,336,082.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,059,879,285.91	1,059,879,285.91
51101	Өмч: - төрийн	1,059,879,285.91	1,059,879,285.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	569,157,397.72	595,622,676.68
51210	Өмнөх үеийн үр дүн	569,157,397.72	569,157,397.72
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	26,465,278.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	425,834,119.69	425,834,119.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,054,870,803.32</u></b>	<b><u>2,081,336,082.28</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,409,125,406.13</b>	<b>2,397,010,371.49</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>296,851,013.73</b>	<b>172,459,895.49</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	293,981,013.73	172,459,895.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,957,109.00	100,496,695.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,882,311.00	66,040,875.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	134,074,798.00	34,455,820.00
120017	Систем хоорондын санхүүжилт /хөрөнгөөр/	70,765,394.73	59,575,549.99
120018	Систем хоорондын санхүүжилт /материалаар/	22,258,510.00	12,387,650.50
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	2,870,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	950,000.00	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	1,920,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,112,274,392.40</b>	<b>2,224,550,476.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,985,997,100.00	2,038,860,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,985,997,100.00	2,038,860,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	126,277,292.40	185,689,676.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,662,568.00	9,639,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	95,614,724.40	176,050,476.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,182,833,550.20</b>	<b>2,361,880,732.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,182,833,550.20</b>	<b>2,361,880,732.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,170,621,453.26	2,314,334,831.62
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,583,195,626.02	1,713,757,622.00
210101	Үндсэн цалин	878,520,088.00	989,359,729.00
210102	Нэмэгдэл	673,835,565.26	693,331,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,839,972.76	31,066,793.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,969,678.42	44,879,230.00
210201	Тэтгэврийн даатгал	1,257,965.00	8,538,932.86
210202	Тэтгэмжийн даатгал	134,597.00	881,594.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	107,677.00	1,064,052.54
210204	Ажилгүйдлийн даатгал	25,240.00	466,172.25
210205	Эрүүл мэндийн даатгал	35,444,199.42	33,928,477.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	80,397,665.00	79,231,696.00
210301	Гэрэл, цахилгаан	14,344,200.00	16,168,108.00
210302	Түлш, халаалт	63,720,385.00	57,846,688.00
210303	Цэвэр, бохир ус	2,333,080.00	5,216,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	147,306,198.91	164,329,533.40
210401	Бичиг хэрэг	13,200,335.00	11,534,094.00
210402	Тээвэр, шатахуун	109,329,940.00	108,620,147.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,912,737.01	13,629,284.00
210404	Ном, хэвлэл	62,700.00	7,976,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	349,650.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,810,069.50	3,650,870.00

**Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210408	Бараа материал акталсны зардал	6,640,767.40	18,738,738.40
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,305,406.50</b>	<b>27,139,204.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	349,770.00	4,262,910.00
210502	Хоол, хүнс	32,578,296.50	22,156,294.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,377,340.00	720,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>46,849,830.00</b>	<b>49,615,745.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	319,100.00	212,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,321,380.00	2,193,945.00
210604	Урсгал засвар	43,209,350.00	47,209,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>42,290,000.00</b>	<b>12,246,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	42,290,000.00	12,246,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,225,664.00</b>	<b>28,146,038.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,986,240.00	16,354,061.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,260,000.00	2,773,089.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	460,000.00	374,000.00
210807	Газрын төлбөр	380,500.00	8,492,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	138,924.00	152,888.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>182,081,384.41</b>	<b>194,989,363.22</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,285,500.00	2,879,667.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,353,467.80	2,316,580.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	179,442,416.61	189,793,116.22
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,212,096.94</b>	<b>47,545,901.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,001,546.00</b>	<b>41,247,602.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	30,374,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,501,546.00	10,872,952.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,210,550.94</b>	<b>6,298,299.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,078,497.54	6,295,904.00
213304	Хөрөнгийн	132,053.40	2,395.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>226,291,855.93</u></b>	<b><u>35,129,638.87</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,240,167.38</b>	<b>8,664,359.91</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,240,167.38	8,664,359.91
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-4,240,167.38</b>	<b>-8,664,359.91</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>222,051,688.55</u></b>	<b><u>26,465,278.96</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,048,657,285.91	425,834,119.68	347,105,709.18	00.00	1,821,597,114.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,048,657,285.91</b>	<b>425,834,119.68</b>	<b>347,105,709.18</b>	<b>00.00</b>	1,821,597,114.77
C07	Тайлант үеийн үр дүн	11,222,000.00	00.00	222,051,688.55	00.00	233,273,688.55
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,059,879,285.91</b>	<b>425,834,119.69</b>	<b>569,157,397.72</b>	<b>00.00</b>	2,054,870,803.32
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,059,879,285.91</b>	<b>425,834,119.69</b>	<b>569,157,397.72</b>	<b>00.00</b>	2,054,870,803.32
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,059,879,285.91</b>	<b>425,834,119.69</b>	<b>569,157,397.72</b>	<b>00.00</b>	2,054,870,803.32
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	26,465,278.96	00.00	26,465,278.96
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,059,879,285.91</b>	<b>425,834,119.69</b>	<b>595,622,676.68</b>	<b>00.00</b>	2,081,336,082.28

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,179,156,703.40</u></b>	<b><u>2,290,591,351.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>66,882,311.00</b>	<b>66,040,875.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	66,882,311.00	66,040,875.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,882,311.00	66,040,875.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,882,311.00	66,040,875.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,112,274,392.40</b>	<b>2,224,550,476.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,985,997,100.00	2,038,860,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,985,997,100.00	2,038,860,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	126,277,292.40	185,689,676.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,662,568.00	9,639,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	95,614,724.40	176,050,476.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,992,594,725.40</u></b>	<b><u>2,218,020,451.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,992,594,725.40</b>	<b>2,218,020,451.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,981,074,174.46</b>	<b>2,177,187,502.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,583,836,153.26	1,716,679,529.00
210101	Үндсэн цалин	878,520,088.00	989,359,729.00
210102	Нэмэгдэл	673,835,565.26	693,331,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,480,500.00	33,988,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,296,681.69	44,836,990.00
210201	Тэтгэврийн даатгал	1,257,965.00	7,979,962.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,038,716.69	36,857,028.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	80,397,665.00	79,231,696.00
210301	Гэрэл, цахилгаан	14,344,200.00	16,168,108.00
210302	Түлш, халаалт	63,720,385.00	57,846,688.00
210303	Цэвэр, бохир ус	2,333,080.00	5,216,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	140,774,075.01	148,217,994.00
210401	Бичиг хэрэг	12,772,000.00	12,296,184.00
210402	Тээвэр, шатахуун	108,326,788.00	110,327,956.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,528,237.01	13,629,284.00
210404	Ном, хэвлэл	77,400.00	8,070,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	349,650.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,720,000.00	3,714,570.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	31,654,999.50	31,027,198.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	1,257,560.00
210502	Хоол, хүнс	26,974,999.50	21,359,638.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,480,000.00	8,410,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	49,656,100.00	122,178,855.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	476,000.00	69,336,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,990,000.00	5,037,155.00
210604	Урсгал засвар	44,190,100.00	47,805,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	42,290,000.00	12,246,400.00
210702	Дотоод албан томилолт	42,290,000.00	12,246,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,750,500.00	20,272,060.00

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,650,000.00	8,632,971.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,260,000.00	2,773,089.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	460,000.00	374,000.00
210807	Газрын төлбөр	380,500.00	8,492,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,418,000.00</b>	<b>2,496,780.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,638,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,780,000.00	2,496,780.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,520,550.94</b>	<b>40,832,949.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,310,000.00</b>	<b>34,534,650.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	30,374,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,810,000.00	4,160,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,210,550.94</b>	<b>6,298,299.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,078,497.54	6,295,904.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/	132,053.40	2,395.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>186,561,978.00</u></b>	<b><u>72,570,900.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>186,561,978.00</u></b>	<b><u>72,570,900.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>186,561,978.00</u></b>	<b><u>72,570,900.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b><u>186,561,978.00</u></b>	<b><u>72,570,900.00</u></b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	186,561,978.00	72,570,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-186,561,978.00</u></b>	<b><u>-72,570,900.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,103,541,200.00	2,098,605,771.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,103,541,200.00	2,098,605,771.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,068,506,500.00	2,064,071,121.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,656,419,900.00	1,656,419,900.00
210101	Үндсэн цалин	929,100,100.00	929,100,100.00
210102	Нэмэгдэл	693,331,100.00	693,331,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,988,700.00	33,988,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,204,400.00	36,857,028.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,204,400.00	36,857,028.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	78,243,800.00	78,243,800.00
210301	Гэрэл, цахилгаан	15,745,200.00	15,745,200.00
210302	Түлш, халаалт	57,281,700.00	57,281,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,216,900.00	5,216,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	124,539,900.00	122,564,938.00
210401	Бичиг хэрэг	12,301,000.00	12,296,184.00
210402	Тээвэр, шатахуун	96,050,900.00	96,050,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,088,000.00	10,263,284.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,800,000.00	3,654,570.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,225,000.00</b>	<b>22,195,060.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	270,060.00
210502	Хоол, хүнс	20,425,000.00	20,425,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>120,470,400.00</b>	<b>120,107,155.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	67,555,400.00	67,555,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	3,637,155.00
210604	Урсгал засвар	48,915,000.00	48,915,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,178,000.00</b>	<b>5,114,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,178,000.00	5,114,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,725,100.00</b>	<b>20,072,060.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	8,432,971.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,773,100.00	2,773,089.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	460,000.00	374,000.00
210807	Газрын төлбөр	8,492,000.00	8,492,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2500000.00</b>	<b>2496780.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,496,780.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35034700.00</b>	<b>34534650.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,034,700.00</b>	<b>34,534,650.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,874,700.00	30,374,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,160,000.00	4,160,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,103,541,200.00</b>	<b>2,098,605,771.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,038,860,800.00</b>	<b>2,032,564,896.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,038,860,800.00	2,032,564,896.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>64,680,400.00</b>	<b>66,040,875.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,680,400.00	66,040,875.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>106.00</b>	<b>108.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	102.00	104.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>185,687,281.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>185,687,281.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>185,687,281.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>60,259,629.00</b>
210101	Үндсэн цалин	60,259,629.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>7,979,962.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,979,962.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>987,896.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	422,908.00
210302	Түлш, халаалт	564,988.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,653,056.00</b>
210402	Тээвэр, шатахуун	14,277,056.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,366,000.00
210404	Ном, хэвлэл	7,950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,832,138.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	987,500.00
210502	Хоол, хүнс	934,638.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,910,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>74,642,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	73,242,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,400,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,132,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,132,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>200,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>185,689,676.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>185,689,676.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,639,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	176,050,476.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 41/159 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

“Найдвартай, баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг” гэсэн зорилгын хүрээнд хүний эрхийг дээдлэн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэт технологийн ашиглалтыг нэмэгдүүлнэ, алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлж ажиллах зорилт дэвшүүлэн үйл ажиллагаанд 2,361.8 сая төгрөгийг зарцуулан ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газарт тайлант хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас үйл ажиллагаанд тодорхой нууцлалын зэрэгтэй хяналт шалгалт хийгдсэн. Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,179.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 32.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 22.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26.7 сая төгрөг буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>			
<b>Авлага</b>	0	66.1	66.1
<b>Бараа материал бэлтгэх урьдчилгаа</b>		66.1	66.1
<b>Бараа материал</b>	210.6	218.4	7.7
<b>Үндсэн хөрөнгө</b>	1,844.1	1,796.7	(47.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,054.8</b>	<b>2,081.3</b>	<b>26.4</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	2,054.8	2,081.3	26.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,054.8</b>	<b>2,081.6</b>	<b>26.7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 218.4 сая төгрөг болж 7.7 сая төгрөгөөр өссөн нь түлш шатлах тослох материал 8.7 сая, Тусгай зориулалтын материал 52.5 сая, эм боох материал 11.4 сая, бусад хангамжийн материал 72.5 сая, нийт 145.4 сая төгрөгөөр үлдэгдэл өссөн, бичиг хэргийн материал 4.5 сая, аж ахуйн материал 2.1 сая мал амьтан 66.4 сая нийт 73.0 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,402.4 сая төгрөг болж 118.2 сая төгрөгөөр өссөн нь Цагдаагийн ерөнхий газраас Автотээврийн хэрэгсэл 40.6 сая, суурин компьютер, принтер болон бусад дагалдах хэрэгсэл 18.9 сая, нийт 59.5 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Prius-xw30 маркийн 2 машин, дуут гэрлэн дохио 10 ш, замын тэмдэг 11ш, драйвер 2ш, болон бусад хөрөнгийг данс бүртгэлд бүртгэсэн 62.7 сая, төсвийн хөрөнгөөр 9.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч нийт 151.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 37 дугаар тогтоолоор 25.0 сая төгрөгийн бш автотээврийн хэрэгсэл, Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 171 тоот албан бичгээр 31 нэр төрлийн 7.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасагдаж, 189.7 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан нь нөлөөлсөн байна.

Авлагын дансны үлдэгдэл 66.1 сая төгрөг болж өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар конторын шинэ барилга баригдаж байгаатай холбоотой тавилга, материал худалдан авахаар гэрээ байгуулсан боловч Ковид-19 цар тахлын өвчлөл, хил гааль хаагдсан нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,081.3 сая төгрөг болж 26.4 сая төгрөгөөр өссөн байна.

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 12.1 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан нь улсын төсвөөс санхүүжих 52.8 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 46.8 сая, туслах үйл ажиллагааны орлого 13.0 сая, нийт 112.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 121.4 сая төгрөгөөр буурсан тус тус нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 179.0 сая төгрөг буюу 8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь олон нийтийн цагдаагийн цалинд өөрчлөлт орсон, коронавируст халдварттай холбоотой ариутгал халдваржуулалд, нэг удаагийн тэтгэмж, шуудан холбоо, зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжих 2,032.4 сая, үйл ажиллагааны орлого 64.6 сая, нийт 2,097.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 6.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,103.5 сая төгрөгөөр баталсан байна.

Ковид-19 цар тахлаас шалтгаалан хил гааль хаасан, тээвэр шатахуун, материалын үнэ өссөнтэй холбоотой 6.4 сая төгрөгийн төсвийг нэмэгдүүлэн баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэх 2,038.8 сая, үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих 64.6 сая, нийт 2,103.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс санхүүжих 2,032.5 сая, үндсэн үйл ажиллагаанаас 66,0 сая, нийт 2,098.6 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 6.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын захирамжаар 101.1 сая, Баруун-Уртын сумын засаг даргаас 70.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 13.0 сая, нийт 185.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс олон нийтийн цагдаагийн цалин хөлс 60.2 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл 7.9 сая, баруун замын хяналтын постын байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 0.9 сая, устгал арга хэмжээ, алтны харуул хамгаалалтай холбоотой хангамж, бараа материалын зардал 25.6 сая, норматив зардал 8.8 сая, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зориулалтаар эргүүлийн 2 машин, урсгал засварын зардал 74.6 сая, дотоод албан томилот 7.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.2 сая, нийт 185.6 сая төгрөгийг зарцуулж, 0.02 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Цагдаагийн ерөнхий газрын даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулж 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.3 хувийн биелэлттэй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар 2,096.8 сая төгрөгийн өртөгтэй конторын барилга бариулахаар 2021 оны 5 сард ЦЕГ/2021/12-001 тоот гэрээг “Их модун” ХХК-тай байгуулж, 2021 оны 12 сарын 25 өдөр хүлээлцэх боловч ковид-19 цар тахлаас шалтгаалж хойшилжээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа болоогүй мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл, мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй асуудал илэрсэнгүй.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар баривчлах, эрүүлчих байрны орлогын бүртгэлтэй холбоотой 1 зөвлөмж өгч бүрэн хэрэгжүүлэн ажиллажээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитын явцад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг үүсээгүй .

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.